

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН  
ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН Ө.НАРМАНДАХ МИНИЙ  
2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР  
ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2024.06.14

Улаанбаатар хот

Тус газрын хуулийн мэргэжилтэн Ө.Нармандах би үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, бусад хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан тогтоомж, дүрэм, журмуудыг хэрэгжүүлэн дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

**НЭГ: Шүүх хуралд оролцсон талаар:**

Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газрын нэхэмжлэлтэй, мөн хариуцагчаар татагдсан болон бусад шалтгаанаар 2024 оны эхний хагас жилийн байдлаар дараах шүүх хурлуудад оролцсон байна. Үүнд:

**НЭГ: ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХ ХУРАЛ:**

Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газарт бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдээс Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21, 32.2.2 дах хэсэгт заасан үүргээ хэрэгжүүлж ажиллаагүйгээс үүссэн өр төлбөрийг барагдуулах чиглэлээр иргэний хэргийн анхан шатны шүүх хуралд давхардсан тоогоор 21 аж ахуйн нэгжтэй холбоотой, 1 494 981 030 (нэг тэр бум дөрвөн зуун ерэн дөрвөн сая есэн зуун наян нэгэн мянга гуч) төгрөг барагдуулах хуралд оролцсон байна.

Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 6 хэрэг маргаанд оролцож, 5 хэрэг маргаан шийдвэрлэгдээгүй хойшилж, 1 хэрэг маргаан шийдвэрлэгдсэн байна.

**ХОЁР: ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХ ХУРАЛ**

Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хандан А.Өнөрцэцэг, П.Нямцэцэг нарын гаргасан нэхэмжлэлд, хариу тайлбарыг гаргаж хуульд заасан хугацаанд тухайн шүүхэд хүргүүлэн ажилласан. А.Өнөрцэцэгийн гаргасан нэхэмжлэлийг хэлэлцэх шүүх хуралд 3 удаа оролцож, нэхэмжлэгчээс гаргасан хүсэлтийн дагуу тухайн шүүх хурал удаа дараа хойшилсон байна. Нэхэмжлэгч П.Нямцэцэгээс Прокурорийн тухай хуульд заасны дагуу тэтгэвэрт гаргахгүй байгаа эс үйлдэхүйт хууль бус болохыг тогтоолгохоор гаргасан нэхэмжлэлийн дагуу анхан шатны шүүх хурал болж нэхэмжлэгчийн нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн байна.

**ХОЁР: Шүүхэд гаргасан нэхэмжлэлийн талаар:**

Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газраас холбогдох байгууллага, аж ахуйн нэгжүүдээс нийгмийн даатгалын өр төлбөр, түүнээс үүссэн өр төлбөрийг барагдуулах чиглэлээр 2024 оны эхний хагас жилийн байдлаар 16 аж ахуйн нэгжид холбогдох 2 365 410 322 (хоёр тэр бум гурван зуун жаран таван сая дөрвөн зуун арван мянга гурван зуун хорин хоёр) төгрөг гаргуулах нэхэмжлэлүүдийг холбогдох дүүргийн шүүхэд гаргасан байна.

Мөн тодорхой оршин суух хаяг нь тодорхойгүй, үйл ажиллагаа нь хаана явуулж байгаа нь мэдэгдэхгүй байгаа 12 аж ахуйн нэгжийг эрэн сурвалжлах нэхэмжлэлийг Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд гаргаж, эрэн сурвалжлах шүүгчийн захирамж гарч харьяалах цагдаагийн байгууллагад хүргүүлэн, эрэн сурвалжлуулах ажиллагааг явуулж байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөр, түүнээс үүссэн өр төлбөрийг барагдуулах чиглэлээр гаргасан нэхэмжлэлээс шүүхийн шийдвэр гарснаар 877 282 662.68 (найман зуун далан долоон сая хоёр зуун наян хоёр мянга зургаан зуун жаран хоёр төгрөг жаран найман мөнгө) төгрөгийг барагдуулсан байна.

**ГУРАВ: Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх**  
**газартай хамтран авч хэрэгжүүлсэн арга**  
**хэмжээний талаар**

Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газраас тус газраас нийгмийн даатгалын шимтгэлийн өр, түүнээс үүссэн алдангийг барагдуулах чиглэлээр Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай хамтран дараах ажил, арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа.

Тус газраас Нийслэлийн шүүхийн шийдвэрт гүйцэтгэх ажиллагаа хийлгүүлэхээр хүргүүлсэн аж ахуйн нэгжүүдийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, тэдгээрийн судалгааг ирүүлэх талаар 2024 оны 04 дүгээр сарын 09-ны өдөр 980 дугаартай албан бичгийг хүргүүлж, 2024 оны 04 дүгээр сарын 19-ны өдрийн 2/1797 дугаартай албан бичгээр хариуг хүлээн авсан байна.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21.1, 32.2.2 дах хэсэгт заасны аж ахуйн нэгжийн үүргээ биелүүлээгүй улмаас нийгмийн даатгалын шимтгэлийн өр, түүнээс үүссэн алдангийг гаргуулах зорилгоор 16 аж ахуйн нэгжтэй холбоотой иргэний хэргийн анхан шатны шүүхээс гаргасан шийдвэр, захирамжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 11 дүгээр зүйл 11.2-д заасны дагуу албадан гүйцэтгэх гүйцэтгэх захирамж, гүйцэтгэх хуудас гаргуулснаар нийтдээ нэр бүхий 10 аж ахуйн нэгжийг Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хүргүүлсэн байна. Иргэний хэргийн анхан шатны шүүхэд гүйцэтгэх хуудас олгуулах хүсэлт хүргүүлсэн 6 шийдвэр, захирамж хүлээгдэж байна.

Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанаас зохих арга хэмжээг авч ажилласнаар 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар 8 аж ахуйн нэгжүүд хэсэгчилсэн байдлаар 101.370.895 (нэг зуун нэг сая гурван зуун далан мянга найман зуун ерэн тав) төгрөгийн төлөлт хийгдсэн байна.

**ГУРАВ: Сургалт, соён гэгээрүүлэх ажлын талаар**

Баянгол дүүргийн Прокурорын газар, Эмнести интернэшил олон улсын байгууллагатай хамтран зохион байгуулсан "Хүний эрх" сэдэвт сургалтад 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдөр цахимаар хамрагдav.

Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/03 дугаар тушаалаар газрыг дэргэдэх "Ёс зүйн дэд хороо"-ны гишүүнээр томилогдож, эхний хагас жилийн байдлаар З удаагийн хуралд оролцож ажиллав.

**ДӨРӨВ: Бусад ажлын талаар**

Ажиллах хугацаанд дээд газраас болон бусад холбогдох газруудаас хугацаатай болон хугацаагүй 5 албан бичиг хүлээн авч, 2 албан бичгийг дээд газар, болон бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэнд хүргүүлсэн байна.

Тус газрын даргаас гаргасан А тушаал 5, Б тушаал 51-н хууль эрх зүйн хэрэглээг нь хянасан байна.

Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газрын Таван шар дахь тасгийн байр нь ус алдаж, албан хаагч ажиллах боломжгүй болсон тул архивын материал тавих тавиурыг албан хаагчдын хамт зөөж, газрын байранд байрлуулсан.

Орлого шимтгэлийн тасгийн байцаагч нартай уулзаж цаашид зохион байгуулах ажил, арга хэмжээний талаар санал солилцож, мэдээлэл авав.

Нийслэл дэх захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалтай холбоотой чиглэл хүсэх тухай албан бичгийг төлөвлөж, ХНХЯам болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төвийн даргын нэр дээр чиглэл хүсэх тухай албан бичгийг хургуулж, хариуг авсан.

Баянгол дүүргийн Засаг даргын тамгын газраас зохион байгуулсан дүүргийн хэмжээний агентлагуудын дунд зохион байгуулсан олон төрөлт тэмцээнд газрын хамт олны хамт оролцов.

## ТАЙЛАН БИЧСЭН